

## ТАНИЛЦУУЛГА

### Хувийн мэдээлэл:

**Овог, нэр:** Жалсрай Насанжаргал

**Хүйс:** эмэгтэй **Ам бүл:**6

**Мэргэжил:** Орос англи хэлний багш

**Холбоо барих утас:**99999461

**Одоогийн албан тушаал:** Дархан-Уул аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн захирал

### Мэргэжлийн зэрэг төгссөн сургууль:

- 2001 онд МУТИС Хүнс үйлдвэрлэл машин тоног төхөөрөмж инженер
- 2009 онд МУДархан дээд сургууль Англи хэлний багш

### Мэргэжил дээшлүүлсэн сургалтын талаар:


- 2008 онд БСШУЯ, Голден Бридж сургалтын төв-Summer institute for english language teachers
- 2013 онд БСШУЯ, БМДИ-Сургуулийн шинэ менежмент, хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүй
- 2014 онд ОХУ, Москва хот, А.С.Пушкины нэрэмжит Орос хэлний дээд сургууль-Русский язык как иностранный и методика его преподавания в зарубежной школе

### Ажилласан байдал:

- 2002-2004 онд Дархан-Уул аймгийн Орхон сумын ЕБ 8-р сургууль-Орос хэлний багш
- 2005-2009 онд Дархан-Уул аймгийн Орхон сумын ЕБ 8-р сургууль-Англи хэл албан бус
- 2011-2012 онд Дархан-Уул аймгийн Орхон сумын ЕБ 8-р сургууль-Сургалтын менежер
- 2012-2016 онд Дархан-Уул аймгийн Боловсрол Соёлын газарт-Гадаад хэлний боловсрол хариуцсан мэргэжилтэн
- 2017 онд Дархан-Уул аймгийн Дархан сумын ЕБ 15-р сургууль-Захирал
- 2022 оноос Дархан-Уул аймгийн Насан туршийн суралцахуйн төв-Захирал

### Бүтээлийн жагсаалт:

- 2005 онд Ард иргэдэд зориулсан англи хэлний анхан шатны сургалтын хөтөлбөр-Сургалтын хөтөлбөр, арга зүй
- 2006 онд Хог хаягдлын менежмент сургалтын хөтөлбөр цахим хичээл-Сургалтын хөтөлбөр, арга зүй, цахим хэрэглэгдэхүүн
- 2006 онд Англи хэл эхлэн суралцагчдад туслах нь-Эцэг эхчүүдэд зориулсан зөвлөмж
- 2010 онд Компьютерийн хэрэглээний програмуудтай ажиллах зөвлөмж- Багш нарт зориулсан гарын авлага



- 2011 онд Хүснэгтэн мэдээлэлтэй ажиллах нь-Багш нарт зориулсан гарын авлага

### Цалин хөлс нэмэгдэл урамшууллын мэдээлэл:

- Үндсэн цалин: ТҮБД-5 1 544 000 мянган төгрөг
- Төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдэл:- 20 хувь
- Орон нутагт ажилласны нэмэгдэл-20 хувь
- Үр дүнгийн урамшуулал улирал бүр-450 хувь

### Холбоо барих мэдээлэл

1. Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрын харьяа Дархан-Уул аймгийн Насан туршийн суралцахуйн төв
2. Утас:70375883

  
**ДАРХАН-УУЛ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 16 өдөр      Дугаар 01-Н/06      Дархан

Ж.Насанжаргалыг захирлын үүргийг  
түр орлон гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/122 дугаар тушаал, аймгийн Засаг даргатай байгуулсан 2023 оны 01 дугаартай хөдөлмөрийн гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авлигатай тэмцэх газраас хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг нь хянан үзээд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй гэж дүгнэсэн байх тул Насан туршийн боловсролын төвийн захирлын албан тушаалын сул орон тоо нөхөгдөх хүртэлх хугацаанд Жалсрайн Насанжаргалыг 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн Насан туршийн боловсролын төвийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.
2. Ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга	Н.Цасчихэр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
Гишүүд:	Б.Энхцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
	Л.Энхцэцэг (Насан туршийн боловсролын төвийн сургалтын менежер)
	Ч.Одхүү (Насан туршийн боловсролын төвийн нягтлан бодогч)
	Н.Даваасамбуу (Насан туршийн боловсролын төвийг нярав, бичиг хэргийн эрхлэгч)

3. Үүрэгт ажлыг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ажил хүлээлцүүлж, дүнг тайлагнахыг ажлын хэсэг (Н.Цасчихэр)-т үүрэг болгосугай.
4. Ж.Насанжаргалын цалинг сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын ТҮБД-5 зэрэглэлийн дагуу 1,126,198 (нэг сая нэг зуун хорин зургаан мянга нэг зуун ерэн найм) төгрөгөөр тооцож, бусад нэмэгдэл, урамшууллыг холбогдох журмыг дагуу тооцож олгохыг Насан туршийн боловсролын төвийн нягтлан бодогч (Ч.Одхүү)-д зөвшөөрсүгэй.
5. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг 30 хоногийн дотор эрх бүхий албан тушаалтанд мэдүүлэхийг Ж.Насанжаргалд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА      Б.АЗЖАРГАЛ

D: ZDTG-2023 zahiramj-5  
4523010109



## БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 5/273

Улаанбаатар хот

Ж.Насанжаргалыг ажилд түр томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь хэсэг, 8.4 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 27.1.10 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 4.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйл, 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1.5 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 1, 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Насан туршийн суралцахуйн төвийн захирлын албан тушаалын тодорхойлолт батлагдаж, сонгон шалгаруулалт зохион байгуулагдан томилох хүртэлх хугацаанд Жалсрайн Насанжаргалыг Дархан-Уул аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн захирлын албан тушаалд 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн түр томилсугай.

2.Ж.Насанжаргалын сарын үндсэн цалинг төрийн үйлчилгээний албан тушаалын ТҮБД-5 зэрэглэлд хамруулан 1,404,000 (нэг сая дөрвөн зуун дөрвөн мянга) төгрөгөөр тогтоон, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 17 хувиар, орон нутгийн нэмэгдлийг 10 хувиар тус тус тооцож олгохыг Дархан-Уул аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн нягтлан бодогч (Г.Мөнхчимэг)-д зөвшөөрсүгэй.

3.Эрхэлсэн ажил үүргээ мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, шуурхай байдлыг ханган, төрийн албан хаагчийн ёс зүйг чанд баримтлан, идэвх санаачилгатай ажиллаж, ажлын үр дүн, гүйцэтгэлийг тухай бүр холбогдох дээд шатны байгууллага, удирдлагад танилцуулж байхыг Ж.Насанжаргалд үүрэг болгосугай.

4.Ж.Насанжаргалтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэх ажил үүрэг, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, цалин хөлсний хэмжээг танилцуулан, хувийн хэрэг хөтөлж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын газар (Ж. Байгаль)-т даалгасугай.

ДАРГА



Т.НЯМ-ОЧИР

0000000000